



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 1/34

Мандалговь

Өмч, эд хөрөнгийн тооллого  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 дэх заалт, "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын 2024 оны жилийн эцсийн өмч, хөрөнгийн тооллогыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Номингэрэл  
(Хөрөнгийн бүртгэл, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн)

Гишүүн: М.Золбоо  
(Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн)  
Э.Саранзаяа  
(Нягтлан бодогч)

2. Тооллогыг 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс 12 дугаар сарын 10-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

3. Өмч хөрөнгө нэг бүрийг нүд үзэн тоолох, илүүдэлтэй болон актлах хөрөнгийн жагсаалтыг гаргаж "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-өөр хэлэлцүүлж, шийдвэрлэхийг комиссын дарга (Б.Номингэрэл)-д даалгасугай.

ДАРГА



С.ХУЛАН

482412091

0923050009 3431274 НД1610